

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

АМЕРИКИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙД МОНГОЛЫН АМЬДРАЛЫГ ТУСГАСАН ТҮҮХИЙН ТОВЧ

Н.Ариунзаяа*

*АНУ-ын Лос-Анжелес хотын Олон улсын хэлний сургуулийн дадлагажигч, сэтгүүл зүйн доктор (Ph.D)

Түлхүүр үг: сэтгүүл зүй, гүрэн, сэдэв, аян замын тэмдэглэл, ертөнц, баримт, аялагч, эрсдэл, Орос, Өргөө, консул, Чингис, сонин, Рузвельт, хэрэм, морьтон, бадарчин.

Эдүгээгээс 150 жилийн тэртээд Америкийн тогтмол хэвлэлд Монголын амьдралыг тусгаж байсан гэхэд итгэхгүй хүн гарч болно. Учир нь тэр үед Монгол улс Манж гүрний эзэмшил, бөглүү хязгаар нутаг байсан юм. Зуу гаруй жилийн өмнө харийн колони болоод, дэлхийн газрын зургаас аль хэдийнэ арчигдаж, гадаад ертөнцөөс бүрмөсөн таслагдсан өчүүхэн Монгол ертөнцийн нөгөө талд орших хүчирхэг гүрний хэвлэлийн сэдэв болно гэдэг санаанд багтамгүй хэрэг билээ.

Гэтэл Монголыг Өрнөдийн сэтгүүл зүй гэрэлт хуудсандаа тусгаж ирсэн түүхэн баримтууд цөөнгүй байна. Монголын тухай бичсэн Америкийн анхны нийтлэлч нь Томас У.Нокс юм. Тэрбээр 1868 онд “The Galaxy” сэтгүүлд “Монголоор аялсан тэмдэглэл” гэдэг аян замын тэмдэглэл нийтлүүлснээр Америкийн сэтгүүл зүй дэх Монголын тухай нийтлэлийн салхийг хагалсан байна. Уг тэмдэглэлийг нийтэлсэн “The Galaxy” сэтгүүл тухайн

үед Америкийн нэр хүнтэй, үндэсний хэмжээний сэтгүүл байсан аж. Нэрт зохиолч Марк Твэйн, Уолт Уитмэн, Хенри Жэймс нар зохиол, нийтлэлээ гаргадаг байсан гэж бодохоор тус сэтгүүл ямархуу зиндааны хэвлэл байсныг мэдэж болно. Зөвхөн Марк Твэйн л гэхэд тус сэтгүүлд наяд шахам өгүүллээ нийтлүүлсэн байдаг.

Томас У.Ноксын тэмдэглэл сэтгүүлчийн эр зориг, эрсдэлтэй аяллын үр дүн болж бүтсэн байна. Тэр үед Монгол байтугай Манжийн эзэнт гүрний нийслэл Бээжин хар тамхины дайны дараа нээлттэй болгосон хотуудын тоонд ороогүй, хаалттай хэвээр байв. Гаднын хүмүүс нутгийн ардын дүрд хувирч нэвтрэх боловч баригдвал шийтгүүлэх, бүр цаазлуулах аюултай байжээ. Ялангуяа Бээжингээс Монголоор дайрч Петербург хүрэх нь Өмнөд туйлд зорчихтой адил эрсдэлтэй гэж үздэг байжээ. Тэр үед Хятад харийн иргэдэд Монголд зорчих зөвшөөрөл өгдөггүй байсан бөгөөд тэр журмыг эвдэж Монголд нэвтэрсэн анхны аялагч нь Францын нэгэн гүн байв. Тэрбээр 1859 онд Хиагтад хүрч, тэндээсээ Бээжинд очих элчийн нарийн бичгийн дарга болж бэрхшээлтэй замыг туулан Бээжинд хүрсэн боловч тэнд илчлэгдэж Шанхай, Хонг-Конгод

зорчих төлөвлөгөө нь нурж Сибирьт албадан буцаагдсан байна.

Томас У.Нокс ийм эрсдэлтэй нөхцөлд аялсан аж. Түүний тэмдэглэлд Хаалганыг Хятад, Монголын хилийн хот гэсэн нь сонирхол татна. Энэ нь өнгөрсөн 150 жилийн туршид монгол нутаг өмнөөсөө хичнээн их хумигдсаныг гэрчлэх баримт юм. Тухайн үед Хаалган хот Хятад, Монголын худалдаа наймааны боомт газар байжээ. Монголчууд говь цөлийг туулж тэмээн жингээр бараа түүхий эдээ зөөдөг байсан бол, хятадууд луусаар тээвэрлэдэг байсан аж. Зохиогч нэг сонирхолтой баримт дурдсан нь хятадуудын хөсөг тээвэрт ашигладаг луус ясанд хадтал муухай орилж, хавь ойрын амгалан тайвныг эвддэг тул сүүлнээс нь хүндхэн чулуу дүүжилдэг байсан гэнэ. Учир нь луус сүүлээ өргөсөн үедээ л орилж чаддаг амьтан юм санж.

Сэтгүүлч Монголын аж байдлыг тодорхойлж бичихдээ «Монголчууд нүүдэлчин улс. Мал сүргийнхээ нүүдлийн маллагааг чухалд тооцно. Зуны цагт задгай газар, байгалийн сайхныг сонгодог бол, өвөлд хүйтнээс хамгаалах нөмөр нөөлөг нутгийг эрэлхийлдэг. Гэрийн их бие нь хөнгөхөн мод бөгөөд түүнийг зузаан эсгийгээр бүрдэг учир нүүж суухад хялбар. Элдэв тавилга сэлт бага учир гэрийг буулгаж, барих нь хурдан бөгөөд Америкийн индианчуудынхтай төстэй. Гэрийн голд түлсэн галын утаа оройд нь байх нүх (тооно)-ээр гарна. Тэмээний хатаасан хоргол түлдэг нь индианчуудын безоны аргал түлдэгтэй төстэй. Гэвч утаа нь их гашуун учраас дотор нь амьдардаг хүмүүст нүдний үрэвсэл элбэг байдаг. Монголчууд эсгий гэртээ их дуртай, байшингаас илүүд үздэг тул суурин иргэд нь ч гэрт суудаг. Гол хот болох Өргөөний гэр, байшингуудаас бүтсэн

гудамж эмх замбараагүй атлаа нэн сонирхолтой» гэхчилэн бичсэн байна.

Томас У. Нокс монголчуудын зан заншлын тухай бичихдээ «Монголчууд хүчтэй, тэсвэр хатуужилтай, ерөнхийдөө сайхан сэтгэлтэй улс. Хятадууд шиг тууштай, шантардаггүй зантай. Бусад нүүдэлчдийн адил дураар чөлөөтэй амьдрахыг эрхэмлэдэг, гаднын зочдыг үл ялгаварлан дайлж цайлдаг зочломтгой ард түмэн. Таниж мэдэхгүй хүмүүс ч тэдний хүндтэй зочин болдог бөгөөд байгаа бүхнээрээ дайлна. Идээ зоогоос зочин хэдийчинээ их хороох тутам төдийчинээ баярлана. Гэхдээ нэлээд бохир заваан учраас сэжигч хүнд бол тийм ч таатай биш. Монголчуудын гол хүнс нь хонины чанасан мах бөгөөд холих хачир, амтлагч, сүмс байдаггүй. Хонийг төхөөрөнгүүтээ л тогоонд чанана. Махаа уур савсуулан байж шөлнөөс нь гаргаад зочдын өмнө шууд тавина. Махны хамгийн сайныг зочиндоо барих бөгөөд хүндэт зочин нь түүнээс бүх хүнд амсуулах ёстой» гэсэн байдаг.

Сэтгүүлч бас Орос улсын Монголын талаар баримталдаг бодлогыг ч хөндөөд авсан байна. Тухайлбал «Туул голын гармаас хоёр бээрийн зайтай нэг хятад хотхон байх нь Өргөө хэмээх монгол хотын захын хороолол (Маймаа хотыг хэлжээ) маягтай юм. Өргөөгийн тэр захын хороолол, төв хэсэг хоёрын хооронд оросууд нэг том байшинтай, тэнд Консул болон хорь гучаад зарц ажилчин сууна. Энд Консул ажиллуулахын цаад бодлого нь Орос боломж гармагц л Монголын томоохон хэсгийг үмхэн авахад бэлэн байхын тулд бөлгөө. Эзлэн дагуулах, газар нутгаа өргөтгөх талаар оросууд бидэнтэй яг адилхан ажээ» гэсэн байна. Томас У.Нокс уг тэмдэглэлдээ XIII зууны үед Тэмүүжин

хэрхэн Монголын Их хаан болсон, Монголын шашин хэдийд хаанаас дэлгэрсэн, XIX зууны үеийн Монгол, Хятад, Оросын хоорондох холбоо, зам харилцаа, байгаль газар зүйн байдал зэрэг олон асуудлыг тусгасан байна.

Бид XIX зууны дунд үед Америкийн хэвлэлд Монголын тухай бичсэнийг ховорхон баримт хэмээн бодож байтал одоо-гоос 110 гаруй жилийн өмнө буюу 1907 онд тэр их гүрний Ерөнхийлөгч Монголын тухай, тэр дундаа Чингис хаанаар толгойлуулсан монголчуудын аян дайны тухай бичиж байсныг олж мэдэв. Эхлээд бусдын гарт хороогдсон Ерөнхийлөгч МакКинлигийн орыг залгаж, улмаар 1904 онд Америкийн албан ёсны Ерөнхийлөгчөөр сонгогдсон Теодор Рузвельт жирийн улс төрч биш зохиолч, аялагч, цэргийн урлаг, байгаль судлаач байжээ. Тэрбээр 1907 онд хэвлэгдсэн түүхч Жеремиа Куртиний “The Mongols a Histori” гэдэг номын өмнөх үгийг бичихдээ Монголын түүх, түүний дэлхий дахины ач холбогдлыг тодорхой өгүүлсэн байдаг.

Теодор Рузвельт Монголчуудын түүхийг XIII зуун буюу Чингис хааны хүчирхэгжлийн үеэс эхлэн бичсэн юм. Тухайлбал «XIII зуун гарахад Чингис Монголын бусад жижиг овгуудын удирдагч нарын нэг адил хэний ч танихгүй хүн байлаа. Овог нь ч, өөрөө ч Төв Азийн нүцгэн талаас гадагшаа нэр алдраа цухуйлгаж ч үзээгүй, бусад нүүдэлчдийнхээ адилаар морио унаж, хонио хариулсан улс байв» гээд Чингис

хаан бага залуу насаа эхлээд өөрийн овгийг захиран барихад зориулсан бөгөөд, дараа нь бусад овог аймгууд хийгээд хөршүүдээ төвхнүүлж, талын морьтнуудын дундах ноёрхлоо ямар ч маргаангүй, бүрэн төгс болгосон тухай өгүүлжээ. Өрсөлдөх гэж санаархсан бүгдийг, хүсэл зоригийг нь биелүүлээгүй бүгдийг хайр найргүй устгаж, тушаал зарлигийг нь эргэлзэлгүй, үг

дуугүй биелүүлэх хүчирхэг чадалтай үнэнч боолуудаар өөрийгөө хүрээлүүлж чадсан тухай ч дурдсан байна.

«Монголчууд гэж дайн тулаанд нэн шаламгай, аян дайнд үл ядардаг, зовлон бэрхшээлийг давж чаддаг, илд нумандаа гарамгай мэргэн хү-

мүүс байлаа. Айдас хүйдэсдээ баригдсан европчуудын хувьд онигор нүдтэй, намхан бахим атлаа хүчирхэг тэдгээр монгол эрс нохойнх шиг хоншоороо гаргаад, жирийн усан нүдэт, цусан зүрхт хүнд үл дийлдэх аймшигт мангас мэт санагдаж байв. Тэд Хятадыг эзлээд, Монголын эзэнт гүрнээ байгуулж орхилоо. Үр сад нь харин Энэтхэгийг эзлээд мөн л агуу их Могол улсыг үндэслэв. Перс ч мөн л хөлд нь үрэгдэв. Морины нуруун дээрх их цэрэг нь үлэмж хурдаар довтолгож, замдаа таарсан бүгдийг арчсаар байлаа. Оросыг бол зүгээр л үлээх төдийд унагаагаад газар шороог нь морин туурайн дор цусан балчиг болтол гишгэлэв. Мажарыг ганцхан тулаанаар л бутцохиж, газар нутгийг нь цусан ангал гартал цавчсанд хаан нь айсандаа

«

*Бид XIX зууны дунд үед
Америкийн хэвлэлд Монголын
тухай бичсэнийг ховорхон баримт
хэмээн бодож байтал одоогоос 110
гаруй жилийн өмнө буюу 1907 онд
тэр их гүрний Ерөнхийлөгч
Монголын тухай, тэр дундаа
Чингис хаанаар толгойлуулсан
монголчуудын аян дайны тухай
бичиж байсныг олж мэдэв*

»

нутгаа орхин зугатжээ. Польшийг мөн дайлаар мордож, Хойт Германы рыцаруудыг Силезид мөхөөв» хэмээн Теодор Рузвельт бичсэн байна.

Тэрээр бас «Монголчуудын байлдан дагууллын үр нөлөө, гэсгээл шийтгэл төсөөлөхийн аргагүй аймшигтай байсан учир агшин зуур дайраад өнгөрсөн зарим нэг нутагт хүртэл арилахын аргагүй ой санамж үлджээ. Зүүн Европын зарим сүмд “Монголчуудын уур хилэнгээс Ертөнцийн эзэн минь гэтэлгэж хайрла” гэсэн залбирал саяхан болтол байсаар л байлаа. Монголын цэрэг хамтын хүчээр ялалтад хүрэх шоргоолж маягийн, зөгий маягийн бүтцийг үүсгэснээр удирдагчийнх нь зан чанар ямар байхаас үл шалтгаалаад ямагт амжилтад хүрэх болжээ» гэсэн байдаг.

Теодор Рузвельт монголчууд эзэлсэн газар орнуудаа захирахдаа Хятадын тогтолцоог зээлж, аажимдаа эзэнт гүрэн бутарч хүч нөлөөгөө алдсаныг дурдаад «Тухайн цагтаа үнэхээр гайхалтай үйл явдал болсны хувьд, өргөн уудам нутагт үр нөлөөгөө хүртээсний учир Ази, Зүүн Европын хөгжил, түүхийг ойлгож мэдэхийг хүссэн хэн ч гэсэн Монголын ард түмний үүх түүхийн талаар бүрэн мэдлэгтэй байх шаардлагатай билээ» гэж дүгнэн хэлсэн нь сонирхолтой юм.

XX зууны эхэн үед Монголын тухай бичсэн Америк сэтгүүлчийн нэг нь “Chicago Daily News” сонины Бээжин дэх сурвалжлагчаар ажиллаж байсан Лютер Андерсон юм. Тэрбээр Бээжинд ажиллаж байх үедээ Монголд сурвалжлах ажлаар ирж “Цөлийн ванлиг-монгол өргөө дэх дипломат бодлого ба нууц явуулга” гэдэг сонирхолтой тэмдэглэл бичиж “Asia: Journal of the American Asiatic Association” сэтгүүлд нийтлүүлсэн байна.

Лютер Андерсон уг тэмдэглэлдээ тухайн үеийн Монгол нь Орос, Хятад хоёр улсын харгислал хүчирхийллийг урин дуудсан бөглүү хязгаар байсан хийгээд Орос, Хятад, Япон улсуудаас Монголын талаар баримталж байсан бодлого, тэдний хооронд хийсэн гэрээ, тохиролцоо болон 1915 оны гурван улсын хэлэлцээрийн үр дүнгийн талаар голчлон бичсэн байдаг. Тэрбээр «Монголоос өөр ийм нууцлаг, хүн мэддэггүй газар дэлхийд ховор. Дундад зууны үед Азийг бүхэлд нь Европын хагастай эзэлж явсан улс өдгөө мартагджээ. XIII зуунд агуу Чингис хаан монголчуудыг нэгтгэн, хэрэн тэнүүчлэх нүүдэлчдийг цэргийн их улс болгон өргөтгөж, Хятад, Төвд, Перс, Месопотами, Оросыг эзэлсэн билээ. Эзэнт гүрэн нь Польшоос Персийн булан, Индостан хүртэл, Константинополиос Хятадын тэнгис, Солонгосоос Ганга мөрөн хүртэл тэлэв. Их хаад нь нийслэл хотоо Бээжинд төвхнүүлэн, агуу их гүрнийг захирсантай Александр, Цезарь, Наполеон нарын улсыг харьцуулбал дэндүү жулдана» гээд дайнч тулаанч энэ орны эдүгээ бууран доройтож унтаа байдалд орсны шалтгаан нь дэлхийн бусад бүх шашнаас хавьгүй хүлцэнгүй, амгалан тайван номлол бүхий Буддизмд орсонд оршино гэсэн дүгнэлт хийсэн байна.

Тэмдэглэлд хоёр их гүрний дунд нэр төдий оршиж байсан Монгол улсын гадаад байдлыг голчлон бичсэний дээр бас нийгмийн байдлын тухай ч дурьдаад авсан байна. Монголчууд «Их хаадаасаа хойш хөгжиж дэвшсэн юм огт үгүй. Дундад зууны үед Монголд айлчилсан аялагчдын тэмдэглэлд тодорхойлж асан тийм гэрт амьдарсаар. Улс төрийн нэгдмэл үзэл, үндэсний төр засаг ч гэж үгүй. Тэднийг нийлүүлэн барьж буй цор ганц зүйл нь

Буддын шашин. Энэ шашны тэргүүн нь Монголын сүсэг бишрэлийн нийслэл болох Өргөө хотноо суух Хутагт. Монголчууд Хутагтыгаа Бурхан багшийн хойт дүр гэдэгт итгэж, амьд бурхан хэмээнэ. Монгол айл бүрд Хутагтын зураг, өмнө нь барьсан арц хүж, зул буй» гэхчилэн бичсэн байна.

Уг тэмдэглэлд Америкийн Төрийн нарийн бичгийн дарга Нокс Хятадад зээл олгож Манжуур дахь Орос, Японы төмөр замын сонирхлыг нь худалдан авахуулах санал тавьсныг Орос, Япон хоёр шууд эсэргүүцэж 1910 оны 7 дугаар сарын 14-ний өдөр хоёр засгийн газар гэрээ байгуулж Манжуур дахь ашиг сонирхлоо хамтран хамгаалах болсон, уг гэрээг байгуулах үеэр олон нийтэд үл гаргах нууц гэрээг давхар баталсан тухай, тэр нууц гэрээгээр Орос улс Гадаад Монголд Хятадын эрх ашгийг шахах, харин Япон яг тийм үйл хэргийг Өвөр Монголд эрхлэхээр тохирсон тухай тодорхой өгүүлсэн байна. Лютер Андерсон сэтгүүлч төдийгүй чадварлаг гэрэл зурагчин байжээ. Тэрбээр Монголын амьдралыг харуулсан олон арван зураг авсны дотор малчдын ахуй байдал, сүм хийд, шашны лам нарын зургууд гол суурийг эзэлдэг. “Монгол адуучин”, “Хийдийн ёслолд лам нар оролцож байгаа нь”, “Монголын тэмээн жинчид Бээжинд” гэх мэт ур чадвар сайтай зургууд олон байна.

XIX-XX зууны зааг үед Монголын тухай хамгийн их бичиж байсан Америкийн сэтгүүлийн нэг нь “Asia: Journal of the American Asiatic Association” юм. 1898 онд анхны дугаараа гаргасан тус сэтгүүл олон жилийн туршид америкчуудад Ази, Дорно дахиныг танилцуулах чухал эх сурвалж болж байжээ. Тус сэтгүүлд нийтлэгдсэн Монголын тухай материалуудаас Аме-

рикийн нэрт зохиолч хатагтай Олив Жилбрэтийн бичсэн “Хятадын их цагаан хэрмийн цаана говь хүрсэн харгуй” хэмээх тэмдэглэлд тухайн үеийн Монголын ахуй байдлыг илүү сонирхолтой өгүүлсэн байдаг.

Тэрээр Бээжингээс ердийн хөсгөөр гарч говь цөлийг туулан явж Өргөөд ирсэн байна. Туршлагатай зохиолчийн хувьд тэмдэглэлээ уран дүрслэл, хүүрнэлийн өнгө аяс давамгайлсан байдлаар бичсэн аж. Зохиогч «Цагаан хэрэм дээрээс хойшоо харвал тэмээн жингээр хэдэн өдөр биш, хэдэн сар явж туулах нууцлагдмал газар тэнийж үзэгдэх нь Монголын их тал ажээ. Тэртээ нэгэн цагт шар арьстны их цэрэг жагсаж, эдүгээ энэ талыг нарны гэрэл гийгүүлж байгаа шиг нэлэнхүйд нь бүрхэж байлаа. Өдгөө тэгтэл нарийхан жимээр ганц морьтон сажлуулж явна. Эртний монголчууд энэ ертөнцөөс бүрэн арчигдаа юу гэлтэй чив чимээгүй. Нэгэн цагт соёл иргэншлийг түйвээж, уулын орой дээгүүр хана хэрэм босгоход хүргэж асан улс үгүй боллоо гэж үү. Чингис хааны үр сад өнөөдөр хаа явна вэ?» гэж эзэнгүй болсон мэт уудам тал нутгийг хараад уулга алдсан байна.

Олив Жилбрэт Монголын тал нутгийг туулсан их аяллынхаа талаар «Аялан явахын баяр баясал шиг зугаа амьдралд ер байдаг болов уу? Энэ зам нар, салхи, бороо, газар дэлхий, асар тэнгэр, ид шидийн гэмээр нууцлагдмал юм. Хааяа замын хажуугийн цагаан тоосон дундуур монгол бадарчин ал-хаж яваа үзэгдэнэ. Тэргэнд зам тавих тэрбээр өнгө өнгийн цэцгэн дундуур туучина. Талыг бүрхэх тэр цэцэгсийн дунд азарган цоор, хонгор зул, хонины нүд, хонхон цэцэг тэргүүтэн зуу зуун өөр цэцэг буй. Гэвч тэр бүгдээс хамгийн үзэсгэлэнтэй нь

гайхамшигт цэнхэр өнгийн бэр цэцэг билээ. Зарим үед ганц нэг морьтон удаан мөлхөх тэрэгний хажуугаар өнгөрөх, эсвэл тэнгэрийн хаяа шиг алсад сууж харагдана. Харин жинхэнэ бясалгагчид бол тэнгэрт хуралдах үүлсийг үл ажран завилж суугаад, нэгэн биед хүлэгдсэн торноосоо чөлөөлөгдөж энэ ертөнцийн амьдрал гэгчийг алсаас тоомжиргүйхэн харж байх шиг санагдана» гэх мэтээр зураглан бичжээ.

Тэрээр цааш нь «Замд тохиох түмэн зүйлийн бэрхшээлийн хувьд жинхэнэ бодитой аюул нь хүн биш, харин ноход байв. Олон зуун жил харуул хамгаалалтад зогсоод эелдэг зөөлөн амьтан болж хувирсангүй, чонотой эвцэлддэг тул тал нутгийн нэг аймшигт араатан болсон ажээ. Дорно дахинд явах хүнд буцлаагүй уснаас болгоомжлохыг захидаг бол, Монгол руу явах хүнд хоёр гартаа нэг нэг саваа барьж яваарай л гэж зөвлөх хэрэгтэй. Өдөртөө гинжилж орхидог нохдыг шөнө тавьж явуулах бөгөөд хашаагаа эргэж тойрч яваа тэр зэрлэгтэй ямар ч тэнэг аянчин тулж эс зүрхлэх бүлгээ» гэжээ.

Олив Жилбрэт монголын ахуй байдал, амьдралын хэвшлийг их нарийн зурж үзүүлсэн байна. Тухайлбал “Монгол гэр гэдэг нь модон ханыг эсгийгээр боож хийсэн оромж юм. Цонхгүй, намхан хаалгатай. Гэрт хувцас хунараа хийх тод өнгөтэй авдар, гуулин сав суулга, зүссэн бяс-лаг, сүүгээр хийсэн согтууруулах ундааны сав, бурхан тахил зэрэг байна. Газрын хөрсийг эсгий болон арьсан ширдгээр бүтээж, хоймортоо намхан ширээ тавьсан нь түрэг маягийн төрх оруулна. Гэрийн голд тулган дээр өглөөнөөс шөнө хүртэл цай чанаж, түүнийгээ давс, тос, шар будаатай ууна... Монгол

ээж тулган дээрх тогоонд хоолоо хийхээс гадна урт том тэвнээр хувцас хунар оёно. Хэдэн гэрийн нэгэнд хурим болж байгаатай таарав. Сүйт залуу хэсэг нөхөдтэйгөө хамгийн сайн морьдоо унаж, үүрийн гэгээнээс өмнө бүсгүйгээ авчирдаг аж. Хятад мөнгөний дархны урласан үс толгойн нэн үзэмжтэй гоёлыг сүйт бүсгүйд инж болгож барьдаг юм байна. Нэг эмэгтэй инжиндээ ирсэн гурван сувдан сондрыг надад харуулаад, тус бүр нь адууны үнэтэй хэмээв. Эрчүүд бас гэр дотор их ажилтай, хөөрөг зөрүүлж, гаансаа нэрнэ. Их баян айл биш бол ганц гэрт бүгд багтана. Тэсгим хүйтэн шөнөд хурга, тугал гээд «“бэлчээрийн ах дүүс” нь хүртэл орж хононо» гэхчилэн бичсэн байна.

Зохиогч монголчуудын гадаад төрхийг илэрхийлж “Хятад хүмүүсийг бодвол бараавтар царай, өргөн хацар, бахим биетэй, нар салхинд гандсан арьс нь элдэв өнгөөр хувирахаа больсон бололтой. Хааяа нэг ухаалаг хүн тааралдах боловч олонх нь ур дарх үйлддэггүй, ажил төрөл эрхэлдэггүй хүмүүс. Бурханы шашинтай тул хорхой шавьж алагдана хэмээж газрын хөрсийг хөндөхгүй мөртөө хонийг бол төхөөрч орхино. Ингэхдээ бурханд харагдахгүй гэж гэрийнхээ ард гаргадаг аж. Монгол хүнд ганц хонь, нэг адуутай өгчихөд л хооллож хувцаслан, хээрээр гэр хийгээд амьдарчихна. Нэмээд ганц үнээ өгчихвөл бүр согтож ч чадна” гэжээ.

Өнгөрсөн зууны хориод оноос Монголд ирсэн америк хүмүүсийн хандлага, сонирхол эрс өөрчлөгдсөн байдаг. Энэ нь Монгол улс Оросын тусламж дэмжлэгтэйгээр харийн дайснаас газар нутгаа чөлөөлж, улмаар тусгаар тогтнолоо зарласантай холбоотой байжээ. Хувьсгалаас өмнө Монголд

аялсан сэтгүүлчид манай ард түмний аж амьдрал, зан заншил, соёл түүхийг илүүтэй сонирхон бичдэг байсан бол, хувьсгалын дараа улс төрийн амьдралд анхаарлаа хандуулж эхэлсэн байдал ажиглагддаг. 1922 онд Хятад, Монгол, Солонгосоор аялж “Умард Хятадаар хэрсэн минь” гэдэг тэмдэглэл бичсэн Харри А.Франк уг тэмдэглэлдээ “Улаан Монголд” гэсэн бүлэг оруулсан бол, 1928 онд ирсэн “ASIA” (“Ази”) сэтгүүлийн сэтгүүлч хатагтай Анна Луиз Стронг “Монголын шинэ, хуучин бурхад” гэдэг тэмдэглэл бичжээ. Тэд Монголыг өөр өөрсдийн үзэл бодлын үүднээс харж бичсэн байдаг. Жишээ нь Харри А.Франк засгийн эрх мэдлээ аваад жил гаруйхан болж байсан Монголын улс төрчид улс орноо хааш нь, хэрхэн залж байгаа хийгээд тэдний хоорондын тэмцэл, түүнээс үүдэн Бодоо, Чагдар-жав нар тэргүүтэй хүмүүс цаазлагдсан, Барон Унгерний Монголд үлдээсэн ул мөр хийгээд улс орны гадаад, дотоод байдал зэргийг халуун сэргэг үед нь өөрийн биеэр үзэж бичсэн хувьдаа үнэ цэнтэй баримтыг үлдээсэн байна. Тэрээр тэмдэглэлийнхээ Монголын тухай хэсгийг “Улаан” хэмээн тодотгосноос үзвэл тухайн үед монголчуудын сонгосон улс төрийн шийдэлд тийм ч таатай хандаж байгаагүй бололтой. Харин коммунист сэтгүүлч Анна Луиз Стронг Монголын сонгож авсан замналд төдийгүй, ерөөсөө монгол хүнд чин сэтгэлээсээ хандаж байсныг “Монгол эр хүн гэж үлгэрийн номыг эс тооцвол миний амьдралдаа үзсэн хамгийн гайхамшигтай амьтан ажээ. Тэр чигтээ дагаад явчихаагүй минь танд л сайн хэрэг болж. Үгүй бол хүний хоёр дахь эхнэр ч болчих байсан юм бил үү. Монголд олон эхнэртэй байдаг гэж хүмүүс ярих юм билээ” хэмээн аавдаа бичсэн

захидалдаа өгүүлснээс тодорхой байна.

Ийнхүү XIX зууны хоёрдугаар хагасаас эхлэн монгол орон, монголчуудыг америкчууд Ерөнхийлөгчөөсөө эхлээд аялагч, сэтгүүлчид нь хүртэл сонирхон судалж ном хэвлэлийн хуудсанд арвин баримт мэдээллийг үлдээсэн байна.

Ишлэл

1. “THE GALAXY” сэтгүүл. 1868 оны 8 дугаар сар.
2. Жеремиа Куртин. 1907. “The Mongols a Histori”.
3. Лютер Андерсон. “Asia: Journal of the American Asiatic Association” сэтгүүл. 1918 оны 1 дүгээр сар
4. Олив Жилбрэт. “Asia: Journal of the American Asiatic Association” сэтгүүл. 1918 оны 1 дүгээр сар.
5. Харри А. Франк. “WANDERING in NORTNERN CHINA”. 1923.
6. Анна Луиз Стронг. “ASIA” сэтгүүл. 1928 оны 6 дугаар сар.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М, Чойсамба Ч. 2005. Сэтгүүл зүйн түүх. УБ.,
2. Чойсамба Ч. 2008. XIX зууны сэтгүүл зүйн түүх.
3. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.,
4. Саруул-Эрдэнэ М. 2017. Монголын тухай Америкийн хэвлэлд. УБ.,
5. “ THE GALAXY” сэтгүүл. 1868 оны 8 дугаар сар.
6. Жеремиа Куртин. 1907. “The Mongols a Histori”.
7. Лютер Андерсон. “Asia: Journal of the American Asiatic Association” сэтгүүл. 1918 оны 1 дүгээр сар
8. Олив Жилбрэт. “Asia: Journal of the American Asiatic Association” сэтгүүл. 1918 оны 1 дүгээр сар.
9. Харри А. Франк. “WANDERING in NORTNERN CHINA”. 1923.
10. Анна Луиз Стронг. “ASIA” сэтгүүл. 1928 оны 6 дугаар сар.